



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/170/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2022 он

*Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,*

*Тэргүүлэх аудитор: Б.Болортуул*

*Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn*

*Аудитын менежер: И.Сэмжидмаа*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn*

*Ахлах аудитор: Д.Нармандах*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn*

*Аудитор: А.Даваасүрэн*

*Утас: 70003775, 88883776*

*Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com*

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	12

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ЗГ	Засгийн газар
НА	Нотлох аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1. Аудитын санал дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэртэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

᠒᠐22.02.23 № ᠒᠐᠖  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОД АЙМГИЙН ХАЛАМЖИЙН  
САНГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Н.БАЗАРРАГЧАА ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

011020010

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>118,519.54</b>	-
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	118,519.54	-
312	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	118,519.54	-
3121	<b>Төгрөг</b>	118,519.54	-
31213	Арилжааны банк дахь харилцах Улсын төсөв	117,262.34	-
31214	Арилжааны банк дахь харилцах Орон нутаг	1,257.20	-
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>118,519.54</b>	=
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>8,456,130.00</b>	=
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	8,456,130.00	-
413	<b>Өглөг</b>	8,456,130.00	-
4136	<b>Бусад өглөг</b>	8,456,130.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	8,456,130.00	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>(8,337,610.46)</b>	=
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	(8,337,610.46)	-
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(8,337,610.46)	-
51210	Өмнөх үеийн үр дүн	3,572,219.06	(6,837,610.46)
51220	Тайлант үеийн үр дүн	(11,909,829.52)	6,837,610.46
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>118,519.54</b>	=

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>14,091,058,110.52</b>	<b>6,186,792,448.71</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,601,000.52</b>	<b>67,519,388.71</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	9,601,000.52	67,519,388.71
120002	Хүүгийн орлого улсын төсөв	4,813,198.49	-
120003	Хүүгийн орлого орон нутаг	70,593.85	4,869.71
120008	Бусад орлого Улсын төсөв	3,814,308.18	67,514,519.00
120009	Бусад орлого орон нутаг	902,900.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,081,457,110.00</b>	<b>6,119,273,060.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	13,898,277,110.00	5,936,655,560.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,898,277,110.00	5,936,655,560.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	183,180,000.00	182,617,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	183,180,000.00	182,617,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,102,967,940.04</b>	<b>6,179,954,838.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,102,967,940.04</b>	<b>6,179,954,838.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,652,700.00	1,304,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,652,700.00	1,304,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,652,700.00	1,304,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	14,098,315,240.04	6,178,649,938.25
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,853,187,170.00	5,951,465,257.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	13,853,187,170.00	5,951,465,257.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	210,806,020.01	174,149,424.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	210,806,020.01	174,149,424.05
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	34,322,050.03	53,035,257.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,322,050.03	53,035,257.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(11,909,829.52)</b>	<b>6,837,610.46</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(11,909,829.52)</b>	<b>6,837,610.46</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	(8,337,610.46)	(8,337,610.46)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(8,337,610.46)	(8,337,610.46)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,500,000.00	1,500,000.00
Тайлант үеийн үр дүн	-	-	<b>(6,837,610.46)</b>	(6,837,610.46)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	6,837,610.46	6,837,610.46

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>14,096,565,910.52</u></b>	<b><u>6,193,332,268.71</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15,108,800.52</b>	<b>74,059,208.71</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	15,108,800.52	74,059,208.71
120002	Хүүгийн орлого улсын төсөв	4,813,198.49	4,869.71
120003	Хүүгийн орлого орон нутаг	70,593.85	-
120008	Бусад орлого улсын төсөв	3,814,308.18	67,514,519.00
120009	Бусад орлого орон нутаг	902,900.00	-
120014	Буцаасан орлого улсын төсөв	5,423,300.00	6,539,820.00
120015	Буцаасан орлого орон нутаг	84,500.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,081,457,110.00</b>	<b>6,119,273,060.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	13,898,277,110.00	5,936,655,560.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,898,277,110.00	5,936,655,560.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	183,180,000.00	182,617,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	183,180,000.00	182,617,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>14,100,019,610.04</u></b>	<b><u>6,193,450,788.25</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,100,019,610.04</b>	<b>6,193,450,788.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,652,700.00</b>	<b>1,304,900.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,652,700.00	1,304,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,652,700.00	1,304,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,095,366,910.04</b>	<b>6,192,145,888.25</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,850,238,840.00	5,964,961,207.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	13,850,238,840.00	5,964,961,207.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	210,806,020.01	174,149,424.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	210,806,020.01	174,149,424.05
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	34,322,050.03	53,035,257.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,322,050.03	53,035,257.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(3,453,699.52)</u></b>	<b><u>(118,519.54)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(3,453,699.52)	(118,519.54)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	3,572,219.06	118,519.54
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	118,519.54	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		118,519.54
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	6,119,273,060.00	5,966,266,107.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	6,119,273,060.00	5,966,266,107.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	1,304,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	1,304,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	1,304,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,119,273,060.00	5,964,961,207.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,119,273,060.00	5,964,961,207.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,119,273,060.00	5,964,961,207.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	6,119,273,060.00	5,966,147,587.46
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	5,936,655,560.00	5,762,506,135.95
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,936,655,560.00	5,762,506,135.95
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	182,617,500.00	129,582,242.80
132001	Орон нутгийн төсвөөс	182,617,500.00	129,582,242.80
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	74,059,208.71
120002	Хүүгийн орлого улсын төсөв		4,869.71
120008	Бусад орлого улсын төсөв		67,514,519.00
120014	Буцаасан орлого улсын төсөв		6,539,820.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>118,519.54</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор А.Даваасүрэн, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 01/58 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь Төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ил тод нээлттэй, шударга байх зарчмыг баримталж иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэхэд бидний эрхэм зорилго оршино.

Зорилтот бүлгийн иргэд, гэр бүлийг нийгмийн харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээнд бүрэн хамруулах “Халамжаас хамгаалалд, хамгааллаас хөдөлмөрт” бодлогыг хэрэгжүүлж, олон нийтийн оролцоо, мэргэшсэн боловсон хүчинд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулахад чиглэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжтэй бөгөөд 2020 оны хүнсний тэжээлийн дэмжлэг үйлчилгээнд Мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт шалгалтыг хэрэгжүүлж 1 албан шаардлагыг өгсөн байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүн 64,216.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 642.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 449.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 7,962.1 сая төгрөг байна. Энэ нь улсын төсвөөс хуваарилсан санхүүжилт буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 7,923.0 сая төгрөгөөр буурсан нь нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмжийн зарцуулалт буурсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 6,119.2 сая мянган төгрөгөөр, нийт зарлагыг 6,119.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,119.2 сая төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 5,936.6 сая төгрөг, 182.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,936.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 182.7 сая төгрөгийн санхүүжилт авч, бусад орлого 74.0 сая төгрөг, нийт 6,193.3 сая мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд бүрэн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,966.1 сая төгрөг буюу 96.3 хувийн гүйцэтгэлтэй буюу 227.1 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Халамжийн сан нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8 орлогын 84.4 сая төгрөгийн мөнгөн гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлсэн.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 191.6 сая төгрөгийн 2 .албан шаардлага, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Халамжийн сангийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ болон сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүдийг дараагийн аудитаар авч үзнэ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн алдаа зөрчилгүй байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөрчлийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Халамжийн сан	1	-	-	-	-	-	1	-	-	-